



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/297

Улаанбаатар хот

Биеийн тамир, спортын газрын албан
хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах
хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 8.4 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга /Ц.Одонбаяр/-д үүрэг болгосугай.
3. “Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт суулгаж, ажиллахыг Ахлах нягтлан бодогч /А.Өнөрцэцэг/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ШАРАВЖАМЦ

000000708

Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны
09 сарын 07 өдрийн А/дугаар тушаалын хавсралт
1297

**Биеийн тамир, спортын газрын төрийн албан
хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Биеийн тамир, спортын газрын хөдөлмөрийн дотоод журам болон төрийн албан хаагчтай холбоотой бусад дүрэм, журам нь энэхүү хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

1.2 Нийтлэг баталгаа:

Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчид нь нийт төрийн албан хаагчдын нэгэн адил Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар хэсгийн Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, нийтлэг баталгаа, нэмэгдэл баталгаагаар хангагдана.

Хамрах хүрээ:

Энэхүү хөтөлбөрт Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчид хамрагдана.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Зорилго:

2.1.1 Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл бололцоог тасралтгүй сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтуудыг хэрэгжүүлсний үндсэн дээр төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн баталгааг хангаж, хөдөлмөрийн бүтээмж, ажлын үр дүн сайжирсан байх нөхцөлийг бүрдүүлэх

2.1.2 Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчийг албан тушаалын тодорхойлолтын дагуу эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэх боломжийг бий болгох үүднээс нийгмийн баталгааг хууль тогтоомжийн хүрээнд хангахад баримтлах бодлогыг тодорхойлоход оршино.

2.2 Зорилт:

2.2.1 Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох.

2.2.2 Төрийн албаны болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хангах арга замыг тодорхойлох.

Гурав. Хөтөлбөрийн зарчим, хэрэгжүүлэх хугацаа, үе шат

3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим:

3.1.1 Төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомжийн хүрээнд ажиллах:

3.1.2 Төрийн албан хаагч нэг бүрийг хамруулах:

3.1.3 Ил тод, нээлттэй хэрэгжүүлэх:

3.1.4 Бодитой байх:

3.1.5 Өөрийн нөөц бололцоог бүрэн дайчлах:

3.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

3.2.1 Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2019-2024 онд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1 Төрийн албаны хүний нөөцийн чадамжийг бүрдүүлж, үйл ажиллагааны тасралтгүй чанарыг хангах:

4.1.1 Албан хаагчдыг ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр сургалтад хамруулах тогтолцоог боловсронгуй болгож, сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх:

4.1.2 Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг нарийвчлан гаргаж, батлуулан ажлын ачааллыг тэнцвэржүүлэх:

4.1.3 Албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэлийг бодитой үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт боловсруулж батлуулан мөрдөх:

4.1.4 Засгийн газраас тогтоосон журмын дагуу үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох:

4.2 Төрийн албан хаагчийн ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулах:

4.2.1 Төрийн албан хаагчийн ажлын байран дахь хөдөлмөрлөх нөхцөл, эрүүл ахуйн стандартыг холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтоолгон дүгнэлт гаргуулж, Засгийн газраас баталсан /Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоол/ өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгсэл, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллах;

4.2.2 Албан хаагчийн ажлын байрны засвар үйлчилгээний судалгаа гарган үе шаттай засвар, тохижилт хийх /халаалт, гэрэлтүүлэг, цахилгаан хангамж гэх мэт/;

4.2.3 Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бичиг хэргийн хэрэгслийн талаар судалгаа авч, жил бүр хангаж байх;

4.2.4 Үйлчилгээний албан хаагчдыг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл болон үйлчилгээнд шаардагдах материалаар тасралтгүй хангах.

4.3 Төрийн албан хаагчийн үр дүнтэй ажиллах бололцоог хангаж, байнгын идэвхтэй үйл ажиллагааг дэмжих:

4.3.1 Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд шаардагдах мэдээллийг тогтмол шуурхай дамжуулах, тэднийг мэдээллээр хангах зорилгоор байгууллага дотор мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулах;

4.3.2 Интернет, дотоод сүлжээний байнгын тасралтгүй ажиллагааг хангах;

4.3.3 Албан ажлын хэрэгцээнд төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд шаардагдах эрх зүйн баримт бичгийн гарын авлагыг хэвлүүлэн төрийн албан хаагчдад өгөх;

4.3.4 Ажилтнууд хэвлэл, ном, сэтгүүлийг ашиглах боломжийг хангах асуудлыг судлан шийдвэрлэх;

4.3.5 Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, ажилласан жилийг харгалзан зэрэг, дэв, ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг ил тод, шударгаар шийдвэрлэх;

4.3.6 Албан хаагчид ажил үүргээ үр дүнтэй биелүүлж, өндөр амжилт гаргасан идэвх зүтгэлийг үндэслэн төрийн одон, медаль, Засгийн газрын хүндэт өргөмжлөл, Биеийн тамир спортын тэргүүний ажилтан, яамны жуух бичиг болон бусад шагналд тодорхойлох болон үнэ бүхий зүйл дурсгах.

4.4 Төрийн албан хаагчийн амьдралын нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх:

4.4.1 Байгууллагын зүгээс банк, санхүүгийн байгууллагатай гэрээ байгуулан албан хаагчдад амьдралын хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор зээл авахад нь дэмжлэг үзүүлэх;

4.4.2 Албан хаагч туслах аж ахуй эрхлэх, ногоо тарих, өөрийн хүсэлтээр суралцахад нь хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэх;

4.4.3 Гэр болон галалгаатай байшинд амьдардаг албан хаагчдад өвлийн бэлтгэлээ хангахад нь зориулан тодорхой мөнгөн тусламж үзүүлэх;

4.4.4 Шинээр гэр бүл болсон болон хүүхэд төрүүлж ам бүл нэмсэн, өрх толгойлсон албан хаагчид санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлэх;

4.4.5 Өөрөө эсвэл гэр бүлийн гишүүн нь хүндээр өвчилж эмнэлэгт удаан хугацаагаар эмчлүүлэх, гадаад улсад эмчилгээ хийлгэх болсон тохиолдолд байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын зохих заалтыг дагаж мөрдөх:

4.4.7 Ажилтан өөрөө болон түүний гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн нас барахад Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тусламж үзүүлэх;

4.4.8 Ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгох;

4.4.9 Албан хаагчдад хоол, унааны мөнгийг сар бүр олгох, инфляцитай уялдуулан нэмэгдүүлж байх.

4.5 Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах:

4.5.1 Төрийн албан хаагчийг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэг удаа хамруулах, үүнтэй холбогдон гарах зардлыг байгууллага хариуцах;

4.5.2 Албан хаагчид шаардлагатай үед спортын анагаах ухааны албаны эмч нараар эмчилгээ хийлгүүлэх;

4.5.3 Албан хаагчдыг хамруулсан идэвхтэй амралт, явган болон тойрон аяллыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах;

4.5.4 Албан хаагчийн спорт, биеийн тамирын арга хэмжээг тогтмолжуулах;

4.5.5 Албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор фитнесийн танхимаар үйлчлүүлэх тодорхой хуваарь гаргаж өгөх;

4.5.6 Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай албан хаагчид тодорхой хэмжээний тусламж олгох;

4.5.7 Төрийн албан хаагчдад эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх ёсны мэдлэг боловсрол олгох;

4.6 Төрийн албан хаагчийн аюулгүй байдлыг хангах:

4.6.1 Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээ авах.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам:

- Төрийн нэгдсэн бодлогоор гүйцэтгэх
- Өөрийн байгууллагын боломжийг ашиглах
- Ижил төстэй байгууллагатай харилцан ажиллах
- Мэргэжлийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Гадаад хамтын ажиллагааны боломжийг нэмэгдүүлэх
- Хамт олны санаачлагыг өрнүүлэх

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Биеийн тамир, спортын газрын Төрийн захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс хариуцна.

6.2 Хөтөлбөрийг газрын удирдлага, албан хаагч, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

6.3 Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг Захиргаа, санхүүгийн хэлтэс жилийн эцэст гаргаж, нийт албан хаагчид болон удирдлагад танилцуулна.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг байгууллагын жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Мөн гадаадын байгууллагын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар санхүүжүүлж болно.

Найм. Хөтөлбөрийн үр дүн

8.1 Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2019-2024 онд хэрэгжүүлснээр БТСГ-ын хүний нөөцийн чадамж, боловсрол, ажлын дадлага, туршлагатай мэргэшсэн ажилтнаар бүрдэж, тэдгээрийг албан тушаалын чиг үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөл, нийгмийн баталгааг хангах, үр дүнтэй ажиллах орчныг бий болгож, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэн, амьдралын баталгаат нөхцөл нь сайжирч төрийн үйл ажиллагааны тасралтгүй чанар, байнгын идэвхтэй үйл ажиллагаа хангагдана.